



УБТЗ ХНН-ийн зураг төслийн төв-д

28/2024

СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК

13374 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 43-р хороо,
13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 83/2,
UB tower, 13-р давхар 1307 тоот
Утас: +(976) 7511 5292, И-мэйл: engineering@soyolon.mn

2024.04.25 № 22

тавай _____-ны № _____-т

Хүсэлт гаргах тухай

“Соёолон Инженеринг” ХХК нь “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ийн хэрэгжүүлж байгаа “Баяжуулах үйлдвэрийн хаягдал өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх” төслийн ажлын нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэж байна.

Уг төслийн хүрээнд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Эрдэнэт өртөө - Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 35 дугаар үеэс 40 дүгээр үе хооронд усны шугамууд огтлолцож байгаа бөгөөд уг огтлолцолтой холбоотой Зам тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/11 тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр төслийн талбайд ажиллаж уг шугам хоолойнуудыг огтлолцуулах боломжтой гэж дүгнэсэн.

Мөн ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу УБТЗ-ын Дохиолол холбооны 1-р анги болон Эрчим хүч, ус хангамжийн 1-р ангиас тус тус техникийн нөхцөл авсан.

Иймд дээрх төмөр замтай огтлолцож байгаа шугамуудын ажлын зургийг зурж өгч бидний ажилд тусална уу.

Ажлын хэсгийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд болон шугамуудын трассын хавсарлт зургийг тус тус хавсаргав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ДОЛГОР

ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

2024.02.02

Дугаар № 24/11/03

Улаанбаатар хот

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйл 10.1.8, Зам тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 148 дугаар тушаалаар батлагдсан "Аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журам"-ын 1 дүгээр бүлгийн 1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Эрдэнэт өртөөнд инженерийн шугам сүлжээ огтлолцуулах боломжийг судлан огтлолцлын түвшин, цэгийг тодорхойлон дараах дүгнэлтийг гаргаж байна.

Нэг. Үндэслэл:

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн ТБ-11-12/7850 дугаартай албан бичиг.

Хоёр. Дүгнэлт:

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хүсэлтийг газар дээр нь судалж үзээд "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замд инженерийн шугам сүлжээнүүдийг дараах байршлуудад огтлолцуулах боломжтой гэж дүгнэв.

- 2.1 Цэвэр усны 250 мл-ийн 3 хос хоолойг Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 40 дүгээр үеэр,
- 2.2 Эргэлтийн усны 1000 мл-ийн 2 хос хоолойг Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 37 дугаар үеэр,
- 2.3 Дулааны шугамын 80 мл-ийн хоолойг Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 36 дугаар үеэр,
- 2.4 Эргэлтийн усны 700 мл-ийн хоолойг Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 35 дугаар үеэр тус тус газрын гадаргын түвшинээс 1 м-ээс багагүй гүнд хамгаалалтын ган хоолойд сүвлэж огтлолцуулах,
- 2.5 Хаягдал усны 1100 мл-ийн 3 хос хоолойг Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 30 дугаар үеэр зам төмрийн толгойн түвшнээс дээш 7.5 метрээс багагүй зайтай байхаар зураг төслийн дагуу;
- 2.6 Дулааны шугамын 80 мл-ийн хос хоолойг Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 26 дугаар үеэр зам төмрийн толгойн түвшнээс дээш 7.5 метрээс багагүй зайтай байхаар зураг төслийн дагуу;
- 2.7 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 17 дугаар үеэр зам төмрийн толгойн түвшнээс утасны унжилтын хамгийн доод цэг хүртэл 7.5 метрээс багагүй зайтай байхаар зураг төслийн дагуу тус тус огтлолцуулах;
- 2.8 Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166 дугаар км-ын 35 дугаар үеэс 40 дүгээр үе хооронд замын зүүн талд оврын шаардлага хангасан 100 метр урт, 5 м өндөртэй эрэг нурахаас хамгаалсан түшиц ханыг байгуулах боломжтой гэж үзэв.

Гурав. Энэхүү дүгнэлтийн 2.1-ээс 2.8-д заасныг үндэслэн Ажлын хэсгээс даалгах нь:

1. Төмөр замын нийтлэг багц дүрэм, MNS 5833:2010 "Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 148 дугаар тушаалаар баталсан "Аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журам"-д заасан шаардлагыг тус тус хангах;
2. Инженерийн шугам сүлжээнүүдийг төмөр замтай огтлолцуулах хэсгийн зургийг төмөр замын мэргэжлийн зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэн, зургийг "УБТЗ" ХНН-ийн Зураг төслийн төвтэй зөвшилцөх;
3. Огтлолцох болон байгууламж барих хэсэгт "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Замын 6 дугаар анги, Дохиолол холбооны 1 дүгээр анги, Эрчим хүч, ус хангамжийн 1-р ангиас техникийн нөхцөл авах;

4. Үүрэн холбооны оператор байгууллагууд болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын салбар зам, бусад инженерийн шугам сүлжээний байгууллагуудаас тодруулга, лавлагаа авах. Зураг төслийн үед бусад инженерийн шугам сүлжээ, шилэн кабельтай огтлолцож байвал эзэмшигч, ашиглагч байгууллагуудыг тодорхойлж, техникийн нөхцөл авч огтлолцлыг зөвшилцөх;
5. Төмөр замтай огтлолцуулахтай холбоотойгоор бий болсон нэмэлт арга хэмжээ, ажлыг зураг төсөлд тусгаж, шаардагдах хөрөнгийг хүсэлт гаргагч бүрэн хариуцах;
6. "УБТЗ" ХНН-ээс авсан техникийн нөхцөлийг үндэслэн зураг төслийг гүйцэтгэж Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын төмөр замын хяналтын мэргэжилтнээр хянуулан барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах;
7. Барилгын ажлыг гүйцэтгэх үед "УБТЗ" ХНН-ийн Эрдэнэт өртөө, Замын 6 дугаар анги, Дохиолол холбооны 1 дүгээр анги, Эрчим хүч, ус хангамжийн 1-р ангид мэдэгдэж батлагдсан зураг төслийн дагуу тэдгээрийн хяналт дор гүйцэтгэх;
8. Энэхүү дүгнэлт нь зөвхөн төмөр замтай инженерийн шугам сүлжээ огтлолцох, байгууламж байрлуулах цэгийг тодорхойлж байгаа бөгөөд хүсэлт гаргагчид ямар нэгэн давуу эрх олгохгүй, "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн аюултай бүсийн гадна байрлах бусдын эзэмшил, ашиглалт, өмчийн ямар нэгэн маргаан, газрын давхцалгүй байх асуудлыг хүсэлт гаргагч бүрэн хариуцна.

Ажлын хэсгийн ахлагч:

Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

 С.Мөнхбаяр

Нарийн бичгийн дарга:

Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

 Б.Батзориг

Гишүүд

Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын шинжээч, улсын ахлах байцаагч

 Д.Батхүү

"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийг төлөөлж:

Тээврийн хяналтын албаны хойд хэсэглэл хариуцсан ахлах байцаагч бөгөөд албаны орлогч дарга

 Б.Энхбаяр

Замын аж ахуйн албаны Гүүр хоолойн инженер

 О.Жигжидсүрэн

Эрчим хүч, ус хангамжийн төвийн инженер

 Ө.Ууганжаргал

Хууль зүйн албаны эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн инженер

 Б.Хайратбек

Зураг төслийн төвийн инженер

 Б.Андараабуд

Эрдэнэт өртөөний орлогч дарга

 Б.Хэнзсүрэн

Замын 6 дугаар ангийн ерөнхий инженер

 А.Туулсайхан

Дохиолол холбооны 1 дүгээр ангийн хэсгийн инженер

 Ц.Энхтүвшин

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Соёолон инженеринг" ХХК-ийн төслийн инженер

 Ө.Тэгшбаяр



**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ЭРЧИМ ХҮЧ, УС ХАНГАМЖИЙН
НЭГДҮГЭЭР АНГИ**

16020 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
3-р хороо, Энгельсийн гудамж
Утас:(976-21) 24-47-20, Факс:(976-21) 24-47-36
И-мэйл: echvod1@ubtz.mn

2024.04.18 № 36/221
танай 2024.04.15 -ны № 17 -т

СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК-Д

Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт
үйлдвэрийн хоорондын замын 166 дугаар км 17-40
дүгээр үеэр инженерийн шугам сүлжээ огтлолцох
цэгт манай эзэмшлийн шугам сүлжээ байхгүй тул
техникийн нөхцөл олгох шаардлагагүй болно.

ДАРГА



Д.НАРАНБАЯР

1636240213



**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДОХИОЛОЛ ХОЛБООНЫ
I ДҮГЭЭР АНГИ**

45040 Дархан сум, Дархан-Уул аймаг
Утас:(02-372) 4-22-40 Факс:(02-372) 4-15-00
И-мэйл: Shoh1@ubtz.mn

2024.04.24 № 25/167
танай _____ ны № _____ -Т

☐ СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК-НД ☐

Танай байгууллагаас ирүүлсэн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 18 тоот хүсэлтийн хүрээнд Эрдэнэт өртөөнөөс Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замд ус дамжуулах шугам огтлолцуулахаар сонгосон талбайд төмөр замын тэнхлэгээс 2,5м зайд 70см ийн гүнд ашиглалтад байгаа физик кабель байгаа тул барилгын ажил гүйцэтгэх үед урьдчилан мэдэгдэж хамтран ажиллана уу.

ДАРГА  Я.АМАРТАЙВАН


2076675

4575240279

ТӨЛӨВЛӨЖ БҮЙ УС ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДУЛААНЫ ШУГАМ УБТЗ ХНН-ийн ТӨМӨР
ЗАМТАЙ ОГТЛОЛЦОХ БАЙРШИЛ, М1:1000

ХАВСРАЛТ

PLAN



ТАНИХ ТЭМДЭГ

- | | | | |
|--|---|--|--------------------------------------|
| | Үндсэн халибар | | Цахилгаан дамжуулах саварын шугам |
| | Овооллын налуу | | Төмөр зам |
| | Төлөвлөлтийн голбай ба хил хязгар | | Инженер-геологийн ааног |
| | Төлөвлөж буй эргэлтийн усны шугам | | Холбооны шугам |
| | Төлөвлөж буй эргэлтийн усны шугам, хубаг | | Төлөвлөж буй цахилгааны кабель шугам |
| | Төлөвлөж буй урдалж шингэлэх, шугам зөвлөх усны шугам | | |
| | Төлөвлөж буй төхөөрөвлөх усны саварын шугам | | |
| | Өвөө бэлдсэн эргэлтийн усны шугам | | |
| | Өвөө бэлдсэн техникийн усны шугам, хубаг | | |
| | Өвөө бэлдсэн бохир усны шугам | | |

ТӨМӨР ЗАМТАЙ ОГТЛОЛЦОХ БАЙРШЛУУД

ДУГААР	ШУГАМЫН НЭР	ШУГАМЫН ДИАМЕТР	ПИКЕТ
БАЙРШИЛ 1	RW-CS16-700-401	DN700	ПК1+66
БАЙРШИЛ 2	ДУЛААНЫ ШУГАМ	2xDN80	
БАЙРШИЛ 3	RW-CS16-1000-418	DN1000	ПК0+14.7
БАЙРШИЛ 4	RW-CS16-1000-419	DN1000	ПК0+13.7
БАЙРШИЛ 5	ДЦС-ын ТЕХНИКИЙН УСНЫ ШУГАМ	3xDN200	ПК2+38.2

1

2

3

4

5

6

7

8

A3

МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
НИЙГЭМЛЭГ



ЗУРАГ ТӨСЛИЙН ТӨВ

УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ

Зөвшилцсөн: РБ

Д

П₃

ШГ



М.Цогт

Ц.Ариунболд

Ю.Нямжаргал

Л.Гунгаажанцан

10/5 2024 он

10.5.2024 он


10/5 2024 он

5/10.2024 он


Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр
хоорондын замд 2 түвшинд дулаан, цэвэр ус, эргэлтийн
усны шугам огтлолцуулах ажлын зураг

 Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам Зураг төслийн төв Утас: 2124-2205	Эрдэнэт өртөө			Тэмдэглэгээ: 38		
	Дарга	Филипов.О.Л	Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замд дулаан, цэвэр ус, эргэлтийн усны шугам 2 түвшинд огтлолцуулах ажлын зураг	Масштаб М1:100		
	Гр.Ахлагч	Б.Баясгалан		Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Гүйцэтгэсэн	С.Цэрэндулам		А.3		5
		Шифр: 25/2024	2024.05			

Дагцү хэлбэрийн зураг



Хөндлөн огтлол



Ул шорооны ирнээгийн төвшин, м		1282.343		1282.343	
Ул шорооны өрөөлөн төвшин, м		1281.805	1281.863	1281.925	
Зай, м		1.0	2.6	2.6	0.6

166км-н замын 36 дугаар үеэр

Тайлбар


- Төмөр зам доогуур дулааны шугам хөндлөн гаргах үед газрын түвшинээс 1.0м-с багагүй гүнд зориулалтын хамгаалалт болох 2x269мм-ийн төмөр дугуй хоолой буудан суулгаж сүвлэн гаргана. Сувагчлалын ажлыг хийхэд мэргэжлийн байгууллагаар заавал гүйцэтгүүлнэ.
- Сувагчлал ажил хийх, хоолой буудах, кабель сүвлэх, ажлын үед төмөр замын ул шорооны доогуур дахиоллын кабель, шилэн кабель газар доор байгаа учраас УБТЗ-ын Замын 6-р анги, Дахиолал холбооны 1-р ангийн бие төлөөлөл болох ажил хариуцсан төлөөллийг газар дээр нь заавал байлцуулна.!!
- Замын зуутын хубаарийг ашиглалтын зуутаар аваб.
- Зураг дээрээс хэмжээ авахгүй.

Анхаарах зүйл


- Цохилтод өрмөөр ажил гүйцэтгэхийг эвбшөөрөхгүй, уг төхөөрөмж нь төмөр замд даргилт өгснөөс ул шороонд гулсалт үүсч бат бэх байдал алдагдаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах өндөр эрсдэлтэй.
- Төмөр зам доогуур, ижил дүс түвшинд ган хоолой огтлолцуулах ажлыг гидро (шингэн) шахуургат төхөөрөмж ашиглан гүйцэтгэсэн тохиолдолд эвбшөөрөх боломжтой.

<p>Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам Зураг төслийн төв</p>	Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын зам			Тэмдэглэгдээ: ЭӨ	
	Дарга	Филлипов, О.Л	Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166км Пк36 үе хооронд хас дулааны шугам 2 түвшинд огтлолцуулах ажлын зураг /2хDN80/	Масштаб М1:100	
	Гр.Ахлагч	Б.Баясгалан		Үе шат	Хуудас
	Хянасан	Б.Андараадүд	Шифр: 25/2024	А.3	3
Утас: 21242205	Гүйцэтгэсэн	С.Цэрэндулам			

Дагцү хэлбэрийн зураг



Хөндлөн огтлол



Ул шорооны црмэгийн төвшин, м		1282.349		1282.349	
Ул шорооны ёроолын төвшин, м		1281.741	1281.743	1281.753	
Зай, м		0.91	2.6	2.6	1.52

Тайлбар

- Төмөр зам доогуур эргэлтийн усны шугам хөндлөн гаргах үед газрын түвшинээс 1.0м-с багагүй гүнд зориулалтын хамгаалалт болох 2x1200мм-ийн төмөр дугуй хоолой буудан суулгаж сүвлэн гаргана. Сувагчлалын ажлыг хийхэд мэргэжлийн байгууллагаар заавал гүйцэтгүүлнэ.
- Сувагчлал ажил хийх, хоолой буудах, кабель сүвлэх, ажлын үед төмөр замын ул шорооны доогуур дохиоллын кабель, шилэн кабель газар доор байгаа учраас УБТЗ-ын Замын 6-р анги, Дохиолол холбооны 1-р ангийн **бие төлөөлөл болох ажил харууцсан төлөөллийг газар дээр нь заавал байлцуулна!!**
- Замын зуурын хуваарийг ашиглалтын зуураар аваб.
- Зураг дээрээс хэмжээ авахгүй.


Анхаарах зүйл

- Цохилтод өрмөр ажил гүйцэтгэхийг эвшөөрөхгүй, уг төхөөрөмж нь төмөр замд даргилт өгснөөс ул шороонд гулсалт үүсч бат дэх байдал алдагдаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах өндөр эрсдэлтэй.
- Төмөр зам доогуур, ижил бүс түвшинд ган хоолой огтлолцуулах ажлыг гидро (шингэн) шахуургат төхөөрөмж ашиглан гүйцэтгэсэн тохиолдолд эвшөөрөх боломжтой.


166км-н замын 37 дугаар үеэр

<p>Монгол-Оросын хувь нилүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам Зураг төслийн төв</p>	Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын зам		Тэмдэглэгдээ: 36
	Дарга	Филиппов, О.Л	Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166км Пк37 үеэр эргэлтийн усны хос шугам 2 түвшинд огтлолцуулах ажлын зураг /RW-CS16-1000-418/
	Гр.Ахлагч	Б.Баясгалан	
	Хянасан	Б.Андараадүд	Шифр: 25/2024
Утас: 2124-2205	Гүйцэтгэсэн	С.Цэрэндүлам	2024.05

Дагцү хэлбэрийн зураг



Хөндлөн огтлол




Ул шорооны ирмэгийн төвшин, м	1284.530				
Ул шорооны ёроолын төвшин, м	1283.853	1283.799	1283.790		
Зай, м	1.0	2.6	2.6	1.1	

166км-н замын 40 дугаар үеэр

Тайлбар

- Төмөр зам доогуур дулааны шугам хөндлөн гаргах үед газрын түвшинээс 1.0м-с багагүй гүнд зориулалтын хамгаалалт болох 3x450мм-ийн төмөр дугуй хоолой дуудан суулгаж сүвлэн гаргана. Сувагчлалын ажлыг хийхэд мэргэжлийн байгууллагаар заавал гүйцэтгүүлнэ.
- Сувагчлал ажил хийх, хоолой дуудах, кабель сүвлэх, ажлын үед төмөр замын ул шорооны доогуур дохиоллын кабель, шилэн кабель газар доор байгаа учраас ЧБТЗ-ын Замын 6-р анги, Дохиолол холбооны 1-р ангийн **бие төлөөлөл болох ажил харуулсан төлөөллийг газар дээр нь заавал байлцуулна!!**
- Замын зуурын хуваарийг ашиглалтын зуутаар авав.
- Зураг дээрээс хэмжээ авахгүй.
Анхаарах зүйл
- Цохилтод өрмөр ажил гүйцэтгэхийг эвшөөрөхгүй, уг төхөөрөмж нь төмөр замд даргилт өгснөөс ул шороонд гулсалт үүсч бат бэх байдал алдагдаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах өндөр эрсдэлтэй.
- Төмөр зам доогуур, ижил бүс түвшинд ган хоолой огтлолцуулах ажлыг гидро (шингэн) шахуургат төхөөрөмж ашиглан гүйцэтгэсэн тохиолдолд эвшөөрөх боломжтой.

 Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам Зураг төслийн төв	Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын зам			Тэмдэглэгээ: 3Ө
	Дарга	Ф.Чилиппов, О.Л	Эрдэнэт өртөө-Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр хоорондын замын 166км Гк40 үеэр 1285.110 үеэр усны 3 шугам 2 түвшинд огтлолцуулах ажлын зураг /3хDN200/	Масштаб М1:100
	Гр.Ахлагч	Б.Баясгалан		Үе шат
	Хянасан	Б.Андараадүд	Хуудас	Бүх хуудас
Утас: 2124-2205	Гүйцэтгэсэн	С.Цэрэндүлам	Шифр: 25/2024	2024.05